

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Я.АМАРЖАРГАЛ

НИЙЛҮҮЛЭГЧ

МОНГОЛ ФАРМ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ж. САЙНБАЯР

**ШИНЭ КОРОНАВИРУСЫН ХАЛДВАРЫН ҮЕД ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ,
ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ,
ОНОШЛУУР НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ**

Дугаар № 92

Улаанбаатар хот

Нэг талаас Эрүүл мэндийн яам (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас Монгол Фарм ХХК ХХК (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2020 оны 03 дугаар сарын 17-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь Эмнэлгийн хэрэгсэл худалдан авах гэрээг (цаашид “бараа” гэх) 10,500,000 (Арван сая таван зуун мянга) төгрөгөөр (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

Хүснэгт 1. Нийлүүлэх бараа

№	Барааны нэр, төрөл	Багцын дугаар	Үйлдвэрлэгч, Улс	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ /НӨАТ орсон/	Нийт үнэ
1	Левифлоксацин	Багц 8	PT.Sanbe Farma - Индонези	ширхэг	1500	7000	10,500,000
Нийт дүн							10,500,000

1. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг 10,500,000 (Арван сая таван зуун мянга) төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөр санхүүжүүлнэ.
2. Нийлүүлэгч нь 1 нэр төрлийн барааг 2020 оны 03 дугаар сарын 17-ны өдрөөс 2020 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг¹;
Тендер ба үнийн хуваарь;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.

Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.

Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

Хүснэгт 2. Санхүүжилтийн хуваарь

№	Барааны нэр, төрөл	Багцийн дугаар	Урьдчилгаа /төгрөг/ ГТН-ийн 15 хар	Гүйцэтгэл /төгрөг/
1	Левифлоксацин	Багц 8		10,500,000
	Нийт дүн			10,500,000

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Нэр томъёо Энэ гэрээнд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:


(а) “Гэрээ” гэж захиалагч, нийлүүлэгчийн хооронд тохиролцсон бараа нийлүүлэх гэрээг хэлнэ. Гэрээ нь талуудын гарын үсэг зурсан гэрээний маягт, түүнийг дагалдах хавсралт, бусад баримт бичгээс бүрдэнэ.


(б) “Гэрээний үнэ” гэж гэрээний дагуу гэрээний үүргээ бүрэн биелүүлж хангалттай гүйцэтгэсний дагуу нийлүүлэгчид төлөх үнийг хэлнэ.

¹ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.


15. Захиалагчийн шаардлагаар гэрээг цуцлах (ГЕН-ийн Зүйл 25)	
ЕН 25	ГЕН-ийн 25-т хамаарах тусгай нөхцөл байхгүй
16. Маргааныг шийдвэрлэх (ГЕН-ийн Зүйл 26)	
ЕН 26	ГЕН-ийн 26-д хамаарах тусгай нөхцөл байхгүй
17. Гэрээнд ашиглах хэл (ГЕН-ийн Зүйл 27)	
ЕН 27.1	Монгол хэл
18. Гэрээнд мөрдөх хууль(ГЕН-ийн Зүйл 28)	
ЕН 28.1	Гэрээнд Монгол Улсын хууль тогтоомжийг мөрдөнө
19. Мэдэгдэл (ГЕН-ийн Зүйл 29)	
ЕН 29.1	Эрүүл мэндийн яам, Засгийн газрын 8 дугаар байр, Улаанбаатар-48, Олимпын гудамж-2
20. Татвар, хураамж (ГЕН-ийн Зүйл 30)	
ЕН 30	Монгол Улсын нутаг дэвсгэрийн гаднаас болон дотоодоос нийлүүлэх эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгалын бодисыг зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэн ХӨСҮТ-д болон эцсийн цэгт захиалагчид хүргэх хүртэл оногдуулсан бүх татвар хураамж, тээвэр, даатгал болон бусад зардлыг нийлүүлэгч бүрэн хариуцна.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Эрүүл мэндийн яамны Эм, эмнэлгийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн хэлтсийн дарга
 Г.Цэцэнсанаа

Эрүүл мэндийн яамны Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
 Т.Бямбасүрэн

Эрүүл мэндийн яамны Эм, эмнэлгийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтэн
 Т.Мөнхтуул

Эрүүл мэндийн яамны Хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн
 Г.Бат-Эрдэнэ


Эрүүл мэндийн яамны нягтлан бичигч
 Э. Эрдэнэцэцэг

Эрүүл мэндийн яамны хуулийн хэлтсийн мэргэжилтэн
 Б.Мөнхцэцэг

Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг Олимпын гудамж 2, Засгийн газрын VIII байр

Телефон: 263695

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Монгол Фарм ХХК-ийн Чанарын менежер
 Х. Сосорбурам

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 10-р хороо, Ногооннуурын гудамж 29/7

Утас: 70132142, 99005576

Харилцах банк: Голомт
Дансны дугаар: 1501150156